



Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны сумдад хөв цөөрөм байгуулах боломжит газрын судалгааны тайлан



ХЯНАСАН:

БӨӨНЦАГААН-ОРОГ НУУРЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА

Б.НЯМ-ОЧИР

БОЛОВСРУУЛСАН:

МЭРГЭЖИЛТЭН

Ш.БАТ-ОЧИР
Ц.ДОРЖНАМЖИН

2024 он

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэхь заалт, 17 дугаар зүйлийн 17.1.5 дахь заалт, Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” улсыг хөгжүүлэх улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 6.3 дахь зорилтын “Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ” зорилтын хэрэгжилтийг хангах, Усны газрын “Нэг сум – Нэг нуур” (333 нуур) хэмжээний хүрээнд сав газар тус бүрээр хөв цөөрөм байгуулах боломжит газрын байршлыг тогтоох 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/907 дугаар албан бичиг, Сав газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн “Хөв цөөрөм байгуулах газрын байршил тогтоох тухай” удирдамжийн дагуу сав газрын хэмжээнд орон нутгийн удирдлагуудын саналыг үндэслэн хөв цөөрөм байгуулах боломжит газрын судалгааг 16 сумын 33 байршилыг газар дээр нь тогтоон ажилласан.


Хөв, цөөрөм байгуулах тохиромжтой газрын үнэлгээ хийхэд хамгийн суурь нөхцөл нь геоморфологийн шинж чанар буюу хонхор хотгор газрын байршлыг тогтоох явдал бөгөөд үүнийг гаргахдаа өндрийн тоон загварыг ашиглах нь дэлхийн хэмжээнд өргөн ашиглагддаг, үр дүнтэй, эдийн засгийн хэмнэлттэй арга юм.

Хур борооны болон хаврын шар усыг хуримтлуулах, байнгын болон түр урсацтай голд тохируулга хийх замаар хөв цөөрөм байгуулах тохиромжтой газрыг тодорхойлох бөгөөд ингэхдээ байгалийн хүчин зүйлс болох хөрсний ус нэвчилт, гадаргын хэвгий, хур тунадас, ууршилтын хэмжээ, ус хурах талбайн хэмжээ, тэр дундаа геоморфологийн тогтцыг чухалчлан үзсэн.

Хамгийн гол хүчин зүйлс нь геоморфологийн шинж чанар, хур тунадас, голын урсцын оролтын хэмжээ, ууршилт гаралтын хэмжээ юм. Үүний дараа хөрсний ус нэвчилт бөгөөд үүнийг инженерийн шийдлээр багасгах боломжтой. Эдгээртэй зэрэгцэн гадаргын урсцын модуль болон ус хурах талбай нь хөв, цөөрөмд хуримтлагдах усны нөөцийн хэмжээг тогтооход нөлөөлнө.

Гадаргын усыг хуримтлуулж, усан сан, хөв цөөрөм байгуулснаар газар тариалан, мал аж ахуйн ус хангамжийн хэрэгцээг хангах, цаашлаад тухайн орчмын уур амьсгалыг сайжруулах боломжтой гэж үзэж байна

Хөв, цөөрөм байгуулах онолын загвар



1.2. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны даргын баталсан 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн “Хөв цөөрөм багуулах газрын байршил тогтоох тухай” удирдамжийн дагуу ажлын хэсэг байгуулж, Баянхонгор аймгийн 16 сумын дэвсгэрт судалгааны ажлыг 3 үе шаттай зохион байгуулсан.

Бэлтгэл ажил:

- Хээрийн судалгааны ажлыг хариуцан зохион байгуулах ажлын хэсэг байгуулах;
- Хээрийн судалгаанд ашиглах ажлын зураг болон мэдээлэл тодруулах хүснэгт боловсруулах.
- Шаардагдах багаж, тоног төхөөрөмж, авто машины бэлэн байдлыг хангах.
- Сумдын Засаг дарга нарт “Хөв цөөрөм” байгуулах газрын байршил тогтоон газар дээр нь очиж ажиллах хуваарийг хүргүүлэх.
- Томилолтын болон шатахууны зардалын тооцоог гаргах.

Хугацаа: VIII/29-IX/02

Хээрийн судалгааны ажил:

- Боловсруулсан ажлын зураг болон сумын удирдлагуудын санал болгосон боломжит газар тус бүр дээр нь очиж төлөв байдлыг тодруулах, байршлыг тодорхойлж, фото зургаар (дроны зураг) баталгаажуулах.

Хугацаа: IX/03-IX/21

Суурин боловсруулалт:

- Хөв цөөрөм байгуулах боломжтой цэгүүдийг зурагт буулгах, үр дүнг jpg, kml, shp өргөтгөлөөр бэлдэх;
- Нэгтгэсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, сав газрын нутаг дэвсгэрийн хөв цөөрөм байгуулах боломжит газрын судалгааны тайланг боловсруулах;
- Нэгтгэсэн тайланг Усны газар болон тухайн Аймаг, сумын Засаг даргын тамгын газарт хүргүүлэх.

Хугацаа: IX/23-IX/26

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Нуурын экосистемийн үнэлгээ, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Ш.Бат-Очир, Газар зүйн мэдээллийн систем, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн Т.Ариунзаяа, Уул уурхай эрчим хүчний асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Доржнамжин, сумдын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч, Хөдөө аж ахуйн Тасгийн дарга, Газрын даамал нар хамтран ажилласан.




Маршрут:

1-р чиглэл буюу Хангайн бүс.

Баянхонгор аймгийн Баянхонгор, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо, Эрдэнэцогт сумд. (3235 км)

2-р чиглэл буюу Говийн бүс.

Баянхонгор аймгийн Өлзийт, Жинст, Богд, Баянцагаан, Баацагаан.(2024 км)




Хээрийн судалгааны ажлын явцаас

1.3. УУР АМЬСГАЛЫН НӨХЦӨЛ


1.3.1. Агаарын температур

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын газар бол засаг захиргааны нэгжийн хувьд Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт ихэнх нь харъяалагдан газар зүйн байрлалаар Хангайн нурууны өвөр хэсэгт оршино. Уур амьсгалын ерөнхий мужлалаар хуурайвтар сэрүүн, хуурайвтар дулаан бүсэд хамаарагдаж байна. Сүүлийн 73 жилд агаарын дундаж температур 1.7°C -ээр нэмэгдэж дулаарсан байна. Агаарын температураас хамаарч усны ууршилт явагддаг. Хөв цөөрөм байгуулах газрын судалгаа хийгдсэн сумдын дулааны улирлын агаарын температурын сарын дунджыг цаг уурын бүсийн хувьд 3 хуваан цаг уурын олон жилийн ажиглалтын мэдээнд үндэслэн график гаргав. Ажиглалтын 20023-2023 оны судалгааны материалуудыг ашиглав.


Хүснэгт 1.1.



Хүснэгт 1.2.




Хүснэгт 1.3.




1.3.2. Хур тунадас

Баянхонгор аймгийн хойд хэсгийг эзлэх Хангайн гол нурууны орчим, түүний салбар уулсын нутагт 300-500 мм хүртэл хур ордог. Аймгийн төв хэсэгт 200-300 мм өмнөд хэсэгт 100 мм-ээс бага хур тунадас ордог. Алтай нурууны Баянцагаан, Гичгэнэ, Их Богд зэрэг уулсаар говь цөл нутгаас арай нэмүү 200 мм хур тунадас унадаг. Гэвч жилд орох тунадасны хэмжээ их хэлбэлзэлтэй ордог. Жилийн нийлбэр тунадасны хэмжээг олон жилийн дунджаар (2003-2023 он) графикаар харуулбал:


Хүснэгт 2.1.



Хүснэгт 2.2.



Хүснэгт 2.3.



1.3.3. Хөрс

Бөөнцагаан нуур-Байдраг голын сав газарт тархсан хөрсний хувьд голын эхэн хэсгээр уулын хөрс ба голын дунд хэсгээр тал газар ухаа толгодын хөрс зонхилж, голын адаг руугаа тал газар, хөндий хотгорын болон давсархаг хөрс тархсан ба голын дагуу хөндийгөөр голын татмын хөмс тахсан байна.

Хүснэгт 3.1 Хөрсний бүлгийн сав газарт эзлэх хувь, %

№	Хөрс	Сав газарт эзлэх хувь, %
1	Уулын хөрс	41.2
2	Тал газар, хөндий хотгорын хөрс	36.2
3	Нам уул, ухаа толгод	12.7
4	Голын татмын хөрс	6.8
5	Давсархаг хөрс	1.2
6	Бусад хөрс ба хөрсгүй газар/ ус, элс	1.8
	Дүн:	100.0

Орог нуур-Түйн голын сав газрын хойд хэсгээр өндөр уулын нугар хээрийн хөрс, цэвдэгт тайгын хөрс, дунд хэсгээр хуурай хээрийн ба цөлжүү хээрийн нунтаг карбонатлаг хар хүрэн хөрс, нунтаг карбонатлаг хүрэн хөрс тус тус зонхилон тархсан. Түүнээс бусдад нь өндөр уулын нугын хөрсөөр солигддог.

Хүснэгт 3.2 Хөрсний бүлгийн сав газарт эзлэх хувь, %

№	Хөрс	Сав газарт эзлэх хувь, %
1	Уулын хөрс	2.13
2	Тал газар, хөндий хотгорын хөрс	36.0
3	Нам уул, ухаа толгод	1.31
4	Голын татмын хөрс	13.6
5	Давсархаг хөрс	5.23
6	Бусад хөрс ба хөрсгүй газар/ ус, элс	40.4
7	Чийгт гарлын хөрс	2.24
	Дүн:	100.0

ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН.


Хөв цөөрөм байгуулах хээрийн судалгааны ажлын үр дүнд хур борооны болон хаврын шар усыг хуримтлуулах, байнгын болон түр урсацтай голд тохируулга хийх замаар хөв цөөрөм байгуулах тохиромжтой нийт 27 газрыг сонгосон.

Хүснэгт 5. Хөв цөөрөм байгуулах боломжит газрын мэдээлэл.

№	Аймаг, сум	Баг	Газрын нэр	Солбилцол	Зориулалт
1	2	3	4	5	
Говийн бүс					
1	Баянхонгор Баацагаан	Баянбулаг 1-р баг	Дэвхрэгийн шанд	45° 25' 39,3" 99° 28' 21,1"	Ан амьтаны усалгаа
2	Баянхонгор Баянцагаан	Аргалант 2-р баг	Яргайтын ам	45° 35' 41,0" 98° 42' 16,0"	Ан амьтаны усалгаа
3	Баянхонгор Богд	Луугар 1-р баг	Элгэн булаг	45° 15' 40,3" 100° 52' 10,1"	Хүн амын унд ахуй, малын усалгаа
4	Баянхонгор Богд	Цэлгэр 4-р баг	Эх нарийны булаг	44° 49' 57,2" 101° 28' 48,8"	Хүн амын унд ахуй, малын усалгаа (Хоолойгоор дамжуулж ёмкость дүүргэх)
5	Баянхонгор Жинст	Хөнөг 3-р баг	Мухарын ам	45° 08' 08,6" 99° 47' 22,9"	Малын усалгаа
6	Баянхонгор Өлзийт	Байн ам 2-р баг	Булган	45° 56' 53,5" 100° 51' 45,8"	Газар тариалан (Бор балгасны услалтын системийн толгойн байгууламж 92 га)
7	Баянхонгор Өлзийт	Худаг урт 4-р баг	Босго	46° 2' 43,6" 101° 11' 32,7"	Малын усалгаа
Хангайн бүс					
8	Баянхонгор Эрдэнэцогт	Сэнжит 1-р баг	Өлзийтийн эхний булаг	46° 30' 8,9" 100° 46' 11,3"	Малын усалгаа
9	Баянхонгор Эрдэнэцогт	Жанжин 4-р баг	Бөөрийн харз	46° 16' 13,5" 100° 50' 40,5"	Хүн амын унд ахуй, малын усалгаа
10	Баянхонгор Баян-Овоо	Уранхайрхан 2-р баг	Ташаагийн дээд булаг	46° 28' 43,3" 100° 20' 06,9"	Хүн амын унд ахуй, малын усалгаа
11	Баянхонгор Баян-Овоо	Асгамба 3-р баг	Шар хөндий	46° 28' 43,3" 100° 20' 06,9"	Ан амьтаны усалгаа, малын усалгаа
12	Баянхонгор Галуут	Сүмбэр 2-р баг	Сүүжийн булаг	46° 32' 41,8" 99° 54' 17,7"	Ан амьтаны усалгаа, малын усалгаа
13	Баянхонгор Галуут	Баянхошуу 6-р баг	Санаачилага гол	46° 41' 37,6" 100° 09' 33,6"	Хүн унд ахуй, тэрбум мод
14	Баянхонгор Жаргалант	Эмээл толгой 4-р баг	Ногоон толгой	47° 00' 40,3" 99° 28' 33,3"	Газар тариалан
15	Баянхонгор Заг	Чандмань Овоо 3-р баг	Сайхан тохой	47° 00' 12,6" 99° 24' 22,0"	Газар тариалан
16	Баянхонгор Гурванбулаг	Хөвийн ам 4-р баг	Балинтын ар	47° 09' 05,7" 98° 36' 22,7"	Малын усалгаа
17	Баянхонгор Гурванбулаг	Хөвийн ам 4-р баг	Дуулгантын хөндий	47° 00' 58,6" 98° 41' 03,1"	Малын усалгаа
18	Баянхонгор Баянбулаг	Сангийн далай 1-р баг	Ар хөтөл нуур	46° 50' 40,1" 97° 48' 17,9"	Малын усалгаа
19	Баянхонгор Хүрээмарал	Хөх бүрд 1-р баг	Хөх бүрдний нуур	46° 31' 31,8" 98° 49' 26,1"	Хүн амын унд ахуй, малын усалгаа
20	Баянхонгор Хүрээмарал	Цорж 4-р баг	Цоржийн төв	46° 31' 16,8" 98° 22' 55,4"	Аялал зугаалга, малын усалгаа
21	Баянхонгор Бууцагаан	Баян 2-р баг	Гашууны булаг	46° 01' 25,8" 98° 51' 40,3"	Малын усалгаа
22	Баянхонгор Бууцагаан	Баян 2-р баг	Баянгийн гол	46° 01' 46,1" 98° 33' 21,7"	Газар тариалан
23	Баянхонгор Бууцагаан	Наран 5-р баг	Цагаан голын адаг	46° 03' 20,3" 99° 16' 12,2"	Малын усалгаа, газар тариалан

24	Баянхонгор Бөмбөгөр	Улаан сайр 1-р баг	Үнхэлцэгийн булаг	46° 28' 04,1" N 99° 46' 33,4" E	Ан амьтаны усалгаа
25	Баянхонгор Бөмбөгөр	Хотын булан 3-р баг	Хотын булан	46° 05' 27,1" N 99° 17' 14,8" E	Газар тариалан
26	Баянхонгор Баянхонгор	Дуурсах 3-р баг	Ойн зурвас	46° 13' 15,6" N 100° 41' 51,34" E	Тэрбум модны усалгаа

Сав газарт хөв цөөрөм байгуулах боломжит газрын байршлууд



Баацагаан сум Баянбулаг 1-р баг Дэвхрэгийн шанд:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. га	10 га	Өндөршил.м	1672
Усны эх үүсвэр	Дэвхрэгийн шанд	Ундарга л/с	0,8

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Булгийн ундарга л/с	0,8	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	75,0	Зориулалт	Ан амьтаны усалгаа
Дундаж гүн.м	0,40	Хэрэглээ	70 аргаль угалз, 100 янгир ямаа, тэх
Эзэлхүүн м ³	30,0	Өртөг. Сая.төг	30,0

Байршил 1



Баянцагаан сум Аргалант 2-р баг Яргайтын ам:


Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. га	-	Өндөршил.м	1536
Усны эх үүсвэр	Худаг	Ундарга л/с	-

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Худгийн ундарга л/с	-	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	80,0	Зориулалт	Ан амьтаны усалгаа
Дундаж гүн.м	0,40	Хэрэглээ	500-600 хар сүүлт зээр
Эзэлхүүн м ³	32,0	Өртөг. Сая.төг	35,0

Байршил 2



Богд сум Луугар 1-р баг Элгэн булаг:


Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. га	-	Өндөршил.м	1276
Усны эх үүсвэр	Элгэн	Ундарга л/с	3,5 (харзлана)

Үүсгэх хөвийн мэдээлэл

Булгийн ундарга л/с	3,5	Хийц	Хөв
Усан мандалын талбай м ²	16,200	Зориулалт	Малын усалгаа
Дундаж гүн.м	1,20	Хэрэглээ	4 айлын 20 хүн, 3000 мал жилийн дөрвөн улиралд, 10 айлын 50 хүн, 6000 мал зун, намрын улиралд ундаална.
Эзэлхүүн м ³	19440	Өртөг. Сая.төг	2500
Далангийн урт.м	360м	Далангийн өндөр.м	2,0

Байршил 3



Богд сум Цэлгэр 4-р баг Эх нарийны булаг:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	5,17	Өндөршил.м	2383
Усны эх үүсвэр	Эх нарийны булаг	Ундарга л/с	1,8

Үүсгэх усан сангийн мэдээлэл

Булгийн ундарга л/с	1,8	Хийц	Булгийн усыг хоолойгоор дамжуулан бэл рүү буулган ёмкостьтод хуримтлуулан ашиглана
Усан мандалын талбай м ²	-	Зориулалт	Хүн амын унд ахуй, малын усалгаа
Дундаж гүн.м	-	Хэрэглээ	15 өрхийн 60 хүн ам, 7000 мал
Эзэлхүүн м ³	40,0	Өртөг. Сая.төг	35,0

Байршил 4



Жинст сүм Хөнөг 3-р баг Мухарын ам:


Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	6,82	Өндөршил.м	1685
Усны эх үүсвэр	Хур бороо, шар усны үер	Ундарга л/с	-

Үүсгэх хөвийн мэдээлэл

Булгийн ундарга л/с	-	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	1000	Зориулалт	Малын усалгаа
Дундаж гүн.м	0,60	Хэрэглээ	10 өрх айл 4000 мал
Эзэлхүүн м ³	600	Өртөг. Сая.төг	200

Байршил 5



Өлзийт сум Байн ам 2-р баг Бор балгас:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	9410	Өндөршил.м	1698
Усны эх үүсвэр	Түйн гол	Өнгөрөлт м ³ /с	3,25

Үүсгэх усан сангийн мэдээлэл

Өнгөрөлт	3,25	Хийц	Толгойн барилга байгууламжыг сэргээх
Усан мандалын талбай м ²	1300	Зориулалт	Газар тариалан
Дундаж гүн.м	1,5	Хэрэглээ	Газар тариалан (Бор балгасны услалтын систем 92 га) 15 өрх, 71 хүн, 5600 мал
Эзэлхүүн м ³	1950	Өртөг. Сая.төг	2500

Байршил 6



Өлзийт сум Худаг урт 4-р баг Босго:


Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	50,2	Өндөршил.м	2092
Усны эх үүсвэр	Хур бороо, шар усны үер	Өнгөрөлт м ³ /с	-

Үүсгэх хөвийн мэдээлэл

Өнгөрөлт	-	Хийц	Хөв
Усан мандалын талбай м ²	6000	Зориулалт	Малын усалгаа
Дундаж гүн.м	0,80	Хэрэглээ	21 өрхийн 115 хүн, 9600 малыг ундаална.
Эзэлхүүн м ³	4800	Өртөг. Сая.төг	2000
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	60,0

Байршил 7



Эрдэнэцогт сум Сэнжит 1-р баг Өлзийтийн эхний булаг:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	9,8	Өндөршил.м	2360
Усны эх үүсвэр	Өлзийтийн эхний булаг	Ундарга л/с	1,5

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	1,5	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	600	Зориулалт	Малын усалгаа
Дундаж гүн.м	0,7	Хэрэглээ	10 өрх, бог 4000, бод 1200 мал ундаална.
Эзэлхүүн м ³	420	Өртөг. Сая.төг	40,0

Байршил 8



Эрдэнэцогт сум Жанжин 4-р баг Бөөрийн харз:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	8,63	Өндөршил.м	2072
Усны эх үүсвэр	Бөөрийн харз	Ундарга л/с	2,8

Үүсгэх цөөрөм мэдээлэл

Ундарга л/с	2,8	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	5900	Зориулалт	Хүн амын унд ахуй, малын усалгаа
Дундаж гүн.м	1,30	Хэрэглээ	12 өрхийн 50 хүн, бог 6000, бод 2280 мал ундаална.
Эзэлхүүн м ³	7670	Өртөг. Сая.төг	270,0
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	30,0

Байршил 9



Баян-Овоо сум Асгамба 3-р баг Шар хөндийн булаг:


Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	9,0	Өндөршил.м	2260
Усны эх үүсвэр	Шар хөндийн булаг	Ундарга л/с	0,5

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	0,5	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	1700	Зориулалт	Ан амьтны усалгаа
Дундаж гүн.м	0,80	Хэрэглээ	80-100 цагаан зээр
Эзэлхүүн м ³	1360	Өртөг. Сая.төг	120,0

Байршил 10



Баян-Овоо сум Уранхайрхан 2-р баг Ташаагийн дээд булаг:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	-	Өндөршил.м	1867
Усны эх үүсвэр	Ташаагийн дээд булаг	Ундарга л/с	1,4

Үүсгэх хөв цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	1,4	Хийц	Хөв
Усан мандалын талбай м ²	9200	Зориулалт	Хүн амын унд ахуй, малын усалгаа
Дундаж гүн.м	0,90	Хэрэглээ	20 өрхийн 93 хүн, 12000 мал ундаална.
Эзэлхүүн м ³	8280	Өртөг. Сая.төг	600,0
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	292

Байршил 11



Галуут сум Сүмбэр 2-р баг Сүүжийн булаг:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км²	1,48	Өндөршил.м	2034
Усны эх үүсвэр	Сүүжийн булаг	Ундарга л/с	1,8

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	1,8	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м²	1500	Зориулалт	Ан амьтаны усалгаа
Дундаж гүн.м	0,80	Хэрэглээ	60-70 аргаль угалз, 30 янгир ямаа, тэх
Эзэлхүүн м³	1200	Өртөг. Сая.төг	100,0
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	160

Байршил 12



Галуут сум Баянхошуу 6-р баг Санаачилага гол:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	2,58	Өндөршил.м	2117
Усны эх үүсвэр	Харганы гол	Ундарга л/с	50,0

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	50,0	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	3300	Зориулалт	Сумын төвийн хүн амын унд ахуй, тэрбум модны усалгаа
Дундаж гүн.м	0,90	Хэрэглээ	Сумын төвийн 680 хүн амын унд ахуйд (Дулааны улирал)
Эзэлхүүн м ³	2970	Өртөг. Сая.төг	400,0
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	230

Байршил 13



Жаргалант сум Эмээл толгой 4-р баг Ногоон толгой:


Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	27277	Өндөршил.м	2033
Усны эх үүсвэр	Байдрагийн гол	Ундарга л/с	80,0

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	80,0	Хийц	Хөв
Усан мандалын талбай м ²	14100	Зориулалт	Жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо
Дундаж гүн.м	0,90	Хэрэглээ	Жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо 6 га, мод үржүүлэг 6 га
Эзэлхүүн м ³	12690	Өртөг. Сая.төг	2500
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	480

Байршил 14



Заг сум Баян-Улаан 2-р баг Халиут:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	27277	Өндөршил.м	1904
Усны эх үүсвэр	Байдрагийн гол	Ундарга л/с	100,0

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	100,0	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	1100	Зориулалт	Жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо
Дундаж гүн.м	0,80	Хэрэглээ	Жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо 4 га
Эзэлхүүн м ³	880	Өртөг. Сая.төг	80,0

Байршил 15



Заг сум Чандмань Овоо 3-р баг Сайхан тохой:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	27277	Өндөршил.м	2014
Усны эх үүсвэр	Байдрагийн гол	Ундарга л/с	80,0

Үүсгэх хиймэл нуурын мэдээлэл

Ундарга л/с	80,0	Хийц	Хиймэл нуур
Усан мандалын талбай м ²	21000	Зориулалт	Жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо
Дундаж гүн.м	0,90	Хэрэглээ	Жимс жимсгэнэ, төмс, хүнсний ногоо 200 га
Эзэлхүүн м ³	18900	Өртөг. Сая.төг	2500
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	620

Байршил 16



Гурванбулаг сум Хөвийн ам 4-р баг Балинтын ар:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	192	Өндөршил.м	2489
Усны эх үүсвэр	Хур бороо, шар усны үер	Ундарга л/с	-

Үүсгэх хөвийн мэдээлэл

Ундарга л/с	-	Хийц	Хөв
Усан мандалын талбай м ²	12600	Зориулалт	Малын усалгаа
Дундаж гүн.м	0,60	Хэрэглээ	16 өрх, хонь ямаа 6000, адуу 300, үхэр 400 толгой мал ундаална.
Эзэлхүүн м ³	7560	Өртөг. Сая.төг	1500
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	321

Байршил 17



Гурванбулаг сум Хөвийн ам 4-р баг Дуулгантын хөндий:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	38,0	Өндөршил.м	2367
Усны эх үүсвэр	Хур бороо, шар усны үер	Ундарга л/с	-

Үүсгэх хөвийн мэдээлэл

Ундарга л/с	-	Хийц	Хөв
Усан мандалын талбай м ²	11200	Зориулалт	Малын усалгаа
Дундаж гүн.м	0,65	Хэрэглээ	14 өрх, хонь ямаа 8000, адуу 500, үхэр 380 толгой мал ундаална.
Эзэлхүүн м ³	7280	Өртөг. Сая.төг	1500
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	60



Баянбулаг сум Сангийн далай 1-р баг Ар хөтөл нуур:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	4,0	Өндөршил.м	2699
Усны эх үүсвэр	Хур бороо, шар усны үер	Ундарга л/с	-

Сэргээх нуурын мэдээлэл

Ундарга л/с	-	Хийц	Нуур сэргээх
Усан мандалын талбай м ²	12500	Зориулалт	Малын усалгаа
Дундаж гүн.м	0,60	Хэрэглээ	18 өрхийн 2500 толгой мал дулааны улиралд ундаална.
Эзэлхүүн м ³	7500	Өртөг. Сая.төг	1200
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	80

Байршил 19



Хүрээмарал сум Хөх бүрд 1-р баг Хөх бүрдний нуур:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	-	Өндөршил.м	2347
Усны эх үүсвэр	Хөх бүрдний булгууд (3)	Ундарга л/с	3,4

Сэргээх нуурын мэдээлэл

Ундарга л/с	3,4	Хийц	Нуур сэргээх
Усан мандалын талбай м ²	43200	Зориулалт	Малын усалгаа
Дундаж гүн.м	0,90	Хэрэглээ	70 өрхийн 9000 бод, 16000 бог малыг ундаална.
Эзэлхүүн м ³	38880	Өртөг. Сая.төг	900 (Булгуудыг хашиж хамгаалах, гүн өрмийн худаг гаргах)

Байршил 20



Хүрээмарал сум Цорж 4-р баг Цоржийн төв:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	18,5	Өндөршил.м	2347
Усны эх үүсвэр	Хур бороо, шар усны үер	Ундарга л/с	-

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	-	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	571	Зориулалт	Малын усалгаа, аялал жуулчлал
Дундаж гүн.м	0,60	Хэрэглээ	15 өрхийн 6500 малыг ундаална.
Эзэлхүүн м ³	324	Өртөг. Сая.төг	1500
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	30

Байршил 21



Бууцагаан сум Баян 2-р баг Гашууны булаг:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	-	Өндөршил.м	2347
Усны эх үүсвэр	Гашууны булаг	Ундарга л/с	0,4

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	0,4	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	240	Зориулалт	Малын усалгаа
Дундаж гүн.м	0,50	Хэрэглээ	10 өрх, 3000-4000 бод, 6000 бог малыг ундаална.
Эзэлхүүн м ³	120	Өртөг. Сая.төг	105

Байршил 22



Бууцагаан сум Баян 2-р баг Баянгийн гол:


Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	878	Өндөршил.м	1698
Усны эх үүсвэр	Баянгийн гол	Ундарга л/с	50,0

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	50,0	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	300	Зориулалт	Төмс, хүнсний ногоо, хадлан
Дундаж гүн.м	1,20	Хэрэглээ	28 га
Эзэлхүүн м ³	360	Өртөг. Сая.төг	300
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	160

Байршил 23



Бууцагаан сум Наран 5-р баг Цагаан гол:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	557	Өндөршил.м	1539
Усны эх үүсвэр	Цагаан гол (Адаг руугаа шургана.)	Ундарга л/с	3,0

Үүсгэх хөвийн мэдээлэл

Ундарга л/с	3,0	Хийц	Хөв
Усан мандалын талбай м ²	479	Зориулалт	Төмс, хүнсний ногоо, хадлан, малын усалгаа
Дундаж гүн.м	0,70	Хэрэглээ	6 га
Эзэлхүүн м ³	360	Өртөг. Сая.төг	300

Байршил 24



Бөмбөгөр сум Улаан сайр 1-р баг Үнхэлцэгийн булаг:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	2,31	Өндөршил.м	2350
Усны эх үүсвэр	Үнхэлцэгийн булаг	Ундарга л/с	0,5

Үүсгэх цөөрмийн мэдээлэл

Ундарга л/с	0,5	Хийц	Цөөрөм
Усан мандалын талбай м ²	249	Зориулалт	Ан амьтаны усалгаа
Дундаж гүн.м	0,70	Хэрэглээ	60 аргаль угалз, 200 янгир ямаа, тэх
Эзэлхүүн м ³	174	Өртөг. Сая.төг	50,0

Байршил 25



Бөмбөгөр сум Хотын булан 3-р баг Хотын булан:


Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	27277	Өндөршил.м	1528
Усны эх үүсвэр	Байдрагийн гол	Өнгөрөлт м ³ с	10,0

Үүсгэх хөвийн мэдээлэл

Ундарга л/с	10,0	Хийц	Хөв
Усан мандалын талбай м ²	16600	Зориулалт	Төмс, хүнсний ногоо, мод
Дундаж гүн.м	0,80	Хэрэглээ	100 га
Эзэлхүүн м ³	13280	Өртөг. Сая.төг	3000
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	360

Байршил 26



Баянхонгор сум Дуурсах 3-р баг мод үржүүлэг:

Ерөнхий мэдээлэл

Ус хурах талбай. Км ²	2,45	Өндөршил.м	1950
Усны эх үүсвэр	Хур бороо, шар усны үер	Өнгөрөлт м ³ с	-

Үүсгэх хөвийн мэдээлэл

Ундарга л/с	-	Хийц	Хөв
Усан мандалын талбай м ²	2450	Зориулалт	Модны усалгаа
Дундаж гүн.м	1,60	Хэрэглээ	5,30 га
Эзэлхүүн м ³	3920	Өртөг. Сая.төг	1500
Далангийн өндөр.м	2,0	Далангийн урт.м	140

Байршил 27



Санал:

1. Хөв цөөрмийг ашиглагч, эзэмшигчтэй болгох. Гарсан зардлын тодорхой хувийг төлүүлэх.
2. Жижиг хөв цөөрмийн нэг загварын зурагтай болгох. Хөв цөөрмийг мэргэжлийн байгууллагаар бариулах.
3. Хөв цөөрмийг хийц, хөрөнгөөр нь ангилан сумын (ангийн орлогоос ан амьтаны зориулалттай жижиг цөөрөм барих) аймгийн, улсын төсвөөр бариулах. Ялангуяа ус, рашаан ашигласны орлогоос (аймгийн төсөв) хөв цөөрмийн зураг төсвийг жилд 3-5-ыг хийлгэх боломжтой.
4. Хөв цөөрмийн эх үүсвэр болсон булаг шандыг давхар хамгаалж хаших.